



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2017 оны 12 сарын 07-ны өдөр

Дугаар 17/07

Даланзадгад сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу “Монгол-Ус” Төрийн Өмчит Үйлдвэрийн Газрын гаргасан 2017 оны 08-р сарын 10-ны өдрийн 2/318 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Алтайн Өвөр Говийн сав газрын захиргааны олгосон 2017 оны 10 сарын 16-ны өдрийн А-12 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж Алтайн Өвөр Говийн Сав газрын захиргааны Газрын доорх усны хяналт шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Батнасан овогтой Санлай.

Нөгөө талаас: Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, БОБШ ХХК-ийн байр 605 тоот, 9019058049 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй “ЖАВХЛАНТ ОРД” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Ч овогтой Монгол эрдэнэ нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2017.01.01-ээс 2017.12.31 хүртэл (нэг) жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Ус ашиглах зориулалт
 - Унд ахуйн: 6922 м³/жил
 - Шавхан зайлуулах ус : 78810 м³

2.2. Нийт ашиглах усны хэмжээ 85732 м³/жил

2.3. Усны чанар, найрлага

Мэргэжлийн хяналтын газрын сорилтын лабораторийн шинжилгээний дүн.

Найрлага	MNS 900:2005 1. Уурхайн ажилчдын ундны ус: хатуулаг-3,37, магни-8,5 нитрит- 0.003 нитрат-0.73 сульфат-32,449
----------	---

	,төмөр-0,005 фтор-0.001, хлор-54,2, PH-7.03
--	--

2.4. Усны эх үүсвэрийн:

Д/д	Зориулалт	Насосны Марк	Худгийн гүн м	Ундарга л/с	Солбилцол	гаргасан огноо
худаг-01	унд ахуй, усжуулалт	ЭЦВ 6-10-80	60	2	101 21 '30.65" 43 16' 37.95"	2016

2.5. Хаягдал усны Хэмжээ: унд ахуйгаас гарах хаягдал усны хэмжээ: м³

Бохир ус	Унд ахуйд	м ³ /хоног	м ³ /жил
Хаягдал ус	Үйлдвэрлэлд	м ³ /хоног	м ³ /жил
Нийт хаягдал ус	Бүгд	м ³ /хоног	м ³ /жил

Бохир ус зайлуулах цэг:

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг.....
 Органик бодис, кг.....
 Эрдэс бодис, кг.....
 Хүнд металл, кг.....
 Аюултай бохирдуулах бодис, кг.....

1.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламж байхгүй.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдол, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

Газрын доорх ус	Гүний худгийн усанд хими болон бактерийн шинжилгээ хийлгэх	2017 оны 3,4-р улиралд- 2 удаа	2.000.000	"Зангат Уул" төслийн баг	MNS 900:2005 стандарт
	Гүний худагт ариун цэврийн бүс тогтоох	2017 оны 3-р улиралд	Дотоод зардалд тусгагдана.	"Зангат Уул" төслийн баг	Ариун цэврийн тухай хууль
	Ус ашиглалтын бүртгэл хийж,	2017 оны туршид	Тоолуурын заалтаар	"Зангат Уул"	Усны тухай хууль

	төлбөрийг улирал тутамд төлөх		төлбөрийг төлнө.	төслийн баг	
--	-------------------------------	--	------------------	-------------	--

2.9. Усны тоолуурын:

LXLG загварын 100мм-ийн голчтой 1 ширхэг усны тоолууртай

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

-“Усны экологи эдийн засгийн үнэлгээг батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтоолоор Алтайн Өвөр говийн сав газарт тогтоосон усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326,327-р тогтоолоор ашиглалтын зориулалтын итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож, тогтоосон хэмжээгээр Төсвийн тухай хуулийн 23.8.9-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

1. 1м³ усны нөөц ашигласны төлбөр - 4433 төг x 0.15% x 1,2 = 797.94 төг
-Шавхан зайлуулах усны төлбөрийн хэмжээ 78810м³/жил x 797.94 төг = **62.885.651 төг**
2. Дүгнэлтэд заасны дагуу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 заалтын дагуу хүн амын унд-ахуйн зориулалтаар ашиглах 6922.5 м³ усыг төлбөрөөс чөлөөлнө.
Нийт ус ашигласны төлбөр болох **62.885.651 төг** (Жаран хоёр сая найман зуун наян таван мянга зургаан зуун тавин нэгэн төгрөг)

/Ус ашигласны төлбөрийг Өмнөговь аймгийн 110000944 дансанд 2017 оны 12 сарын 30-ны дотор 100% төвлөрүүлэх./

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.7 Ус бохирдуулсны төлбөрийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1, 7.2 үндэслэн /Засгийн газрын тогтоол гарснаар хүчин төгөлдөр болно/ барагдуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Ус ашиглуулагчийг төлөөлж:


АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ УСНЫ
НӨӨЦИЙН НЭГДСЭН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

...../А.МӨНХЗОРИГ/

Хаяг: Өмнөговь аймаг, Даланзадгад
сум, 3-р баг, төрийн банкны байр.
Харилцах утас: 70534080
Факс: 70534081

Ус ашиглагчийг төлөөлж:

“ЖАВХЛАНТ ОРД” ХХК-НИЙ
БАЙГАЛЬ ОРЧНИЙ МЭРГЭЖИЛТЭН

...../Ч.МОНГОЛ ЭРДЭНЭ/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, БОБШ ХХК-ийн
байр 605 тоот
Харилцах утас: 70111101
Факс: 70111101

